



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ**

2015 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс:

**Хэлэлцсэн нь:**

Хөдөө аж ахуйн "Халх гол" чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын 2015 оны 75 дугаар тогтоолын талаар ирүүлсэн 3900 иргэний өргөдлийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаагийн мэдээллийг хэлэлцсэн тухай

**Шийдвэрлэсэн нь:**

Нэг. Улсын Их Хурлын 2015 оны 75 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхдээ дараах чиглэлээр анхаарч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгох нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1/Хөдөө аж ахуйн чөлөөт бүс, хөдөө аж ахуйн бүс байгуулахтай холбогдсон эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох, шаардлагатай бол хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Чөлөөт бүсийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу хөдөө аж ахуйн "Халх гол" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлахдаа орон нутгийн өөрөө удирдах байгууллага, ард иргэд, эрдэмтэн, судлаачдын саналыг авах;


3/Чөлөөт бүсийн талбайд хамаарч буй газрыг иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлж, ашиглуулж байгаа үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль бусаар хагалсан талбайн үнэлгээг тогтоож, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох арга хэмжээг зохион байгуулах;

4/Малчид, орон нутгийн иргэдийн хэвийн ажиллаж амьдрах болон малын бэлчээрийн нөхцөл байдлыг алдагдуулахгүй, зэрлэг ан амьтдын амьдрах орчин нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, хагалах талбайг зохистой түвшинд хязгаарлаж хөрсийг хамгаалах, эко системийг харгалзсан арга хэмжээнүүдийг авч ажиллах.

Хоёр.Биелэлтийг 2015-2016 оны намрын чуулганы хугацаанд багтаан зохион байгуулж, тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Хүнс, хөдөө аж ахуйн яам /Р.Бурмаа/-нд даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



О.БААСАНХҮҮ

Г.НЯМСҮРЭН